



БИЧИЛ УУРХАЙН

Мэдлэгийн төв

Бичил уурхайн Мэдлэгийн төвийн Ажлын алба

Бичил уурхайн Мэдлэгийн төвийн Ажлын алба нь Мэдлэгийн төвийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан үр өгөөжтэй, үр дүнтэй, тогтвортой байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэн ажиллана. Гол үндсэн үүрэг нь:

1. Зохицуулалт ба менежмент: Мэдлэгийн төвийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдах, стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хяналт тавих, жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө болон төсвийг тооцоолон боловсруулж Удирдах зөвлөлөөр батлуулах, улирал бүр тайлан бэлдэж Удирдах зөвлөлд танилцуулах.
2. Мэдлэг хуваалцах, харилцаа холбоо ба сүлжээ үүсгэх: Мэдлэгийн төвийн үйл ажиллагааны дотоод харилцаа холбоог бий болгох, бичил уурхайн үйл ажиллагааны талаар олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, бичил уурхайн мэдлэгийн төвийн оролцогч талуудын хамтын ажиллагааг идэвхжүүлэх, бусад улсын мэдлэгийн төвтэй хамтын ажиллагааг бий болгох.

Мэдлэгийн төвийн үйл ажиллагааны үр дүнтэй, тогтвортой хэрэгжилтийг хангах зорилгоор Ажлын албанд УУХҮЯ-аас хоёр мэргэжилтэн ажиллана. Тогтвортой бичил уурхай төслийн хэрэгжилтийн хугацаанд Ажлын алба нь төсөл болон Датаком компанитай хамтарч ажиллана. Тогтвортой бичил уурхай төсөлтэй хамтран Ажлын алба нь сэдэвчилсэн бүлгүүдэд хурал, уулзалт, семинар болон бусад арга хэмжээ зохион байгуулахад нь дэмжлэг үзүүлнэ.

ШХА болон Тогтвортой бичил уурхай төслийн дэмжлэг

Тогтвортой бичил уурхай төсөл нь Датаком компанитай гэрээ байгуулан бичил уурхайн мэдлэгийн төвийн цахим платформын хөгжүүлсэн. Платформын нээлт 2018 оны 3-р сарын 1-д болж олон нийтэд танилцуулагдаж УУХҮЯ-нд хүлээлгэн өгсөн. Датаком компани нь Ажлын албаны ажилтнуудад техникийн сургалт явуулж, мэдлэгийн төвийн гар утасны аппликейшн хийх, e-commerce хэрэгсэл, судалгаа дүн шинжилгээ хийх, мэдээллийн цахим сургалтын хуудасны хөгжүүлэлтийн ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

Тогтвортой бичил уурхай төслийн Мэдлэгийн төв, мэдээлэл харилцааны эксперт нь Ажлын албаны чадавхыг бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ. Төслийн эксперт нь Мэдлэгийн төвийн Ажлын албаны ажилтнуудад болон мэдлэгийн төвийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхээр долоо хоногийн нэг өдөр ажиллана. Тус эксперт нь Мэдлэгийн төвийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, платформын хөгжилд үнэлэлт, дүгнэлт өгнө.